



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ
ЗАРИМ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ
ЗАРДЛЫН ТООЦОО

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2024

5 сар



Судалгааг захиалагч:

Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг хянасан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааг удирдсан:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D.)

Судалгааны багийн гишүүд:

Х.Буянбат

Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын
Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

О.Түвшинсанаа


Нийтийн эрх зүйн секторын Эрдэм
шинжилгээний ажилтан

Г.Болор-Эрдэнэ

Хувийн эрх зүйн секторын Эрдэм
шинжилгээний ажилтан

С.Нарантунгалаг

Хувийн эрх зүйн секторын Эрдэм
шинжилгээний ажилтан



**ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ
ЗАРДЛЫН ТООЦОО**

УДИРТГАЛ.....	4
I.ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ .	6
1.1.Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох	7
1.2.Хүний нөөцийг тодорхойлох	9
1.3. Гарах зардлыг урьдчилан тооцох	11
1.4. Үр дүнг тооцох.....	12
1.5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.....	13
II. ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ.....	14
2.1.Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох	16
2.2.Хүний нөөцийг тодорхойлох	17
2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох	20
2.4. Үр дүнг тооцох.....	21
2.5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.....	22
III.ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ.....	23
3.1.Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох	24
3.2.Хүний нөөцийг тодорхойлох	25
3.3.Үр дүнг тооцох.....	26
IV. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ.....	28
4.1.Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох	28
4.2.Хүний нөөцийг тодорхойлох	30
4.3.Гарах зардлыг урьдчилан тооцох	33
4.4.Үр дүнг тооцох.....	33
4.5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.....	34
V.ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ	37
VI. АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	39
VII. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ	44
ДҮГНЭЛТ	52

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5.5.1-д заасан “Хүний эрхийг хамгаалахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, хамтран оролцох эрх зүйн орчныг бүрдүүлж, хөгжүүлэх” зорилтын хүрээнд, “Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж, “Засаглалын үйл ажиллагаанд иргэд эрх тэгш оролцон үзэл бодлоо илэрхийлнэ” гэж, “Эвлэлдэн нэгдэх боломж, чадавхыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх орчныг бүрдүүлэх, нийгмийн бүлгүүд засаглалын үйл явцад тэгш оролцох боломжийг хангасан тогтолцоог бүрдүүлнэ” гэж тус тус заасан. Түүнчлэн, “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулжээ.


Хууль тогтоомжийн тухай хууль¹-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасан. Үүний дагуу, хүний эрхийн багц хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх болон нэмэгдэх үүргийн улмаас бий болох зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан тооцож, судалгаа хийх шаардлага үүссэн байна.

Судалгааны зорилго. Хүний эрхийг хангахтай холбоотой багц хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, хялбарчлах болон бууруулах боломжит хувилбар бүхий санал боловсруулахад энэхүү судалгааны зорилго чиглэгдэнэ.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын 3.4.1-т заасны дагуу, хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан иргэнд шинээр болон нэмэлт зардал үүсгээгүй байх тул энэхүү зардлын тооцооны судалгааг төрийн байгууллага болон хуулийн этгээдэд үүсэх зардлыг тооцох агуулгаар дараах хуулийн төслүүдийн хүрээнд гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

¹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, <https://legalinfo.mn/mn/detail/11119> (сүүлд үзсэн: 2024.04.22)

- 
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
 - Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
 - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
 - Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
 - Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
 - Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
 - Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
 - Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
 - Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу дор дурдсан хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд зардал үүсэхгүй байх тул судалгааны хүрээнд тооцоогүй болно. Үүнд:

- Дайчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

I.ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд цагдаагийн албан хаагчийг мэргэшүүлэх, ур чадварыг хөгжүүлэх, албан тушаалын буюу ажлын байрны сургалтад хамруулах, албаны нохой ашиглах болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсгийн аюулгүй ажиллагааны сургалтыг төлбөртэй зохион байгуулахаар тусгажээ.

Төрийн байгууллагын зардлын тооцоо

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Аргачлалын 4.4.6-д заасны дагуу төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээ буюу дараах дүрэм, журам, стандарт, кодчиллыг батлах чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг тус тооцоонд тусгаагүй. Үүнд:

- 17.3.Энэ хуулийн 17.1.1-д заасан сургалтын хөтөлбөр, агуулга, журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 17.6.Энэ хуулийн 17.5-д заасан сургалтын төлбөрийн хэмжээг дотоод хэргийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд, төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгт хамаарах дараах зохицуулалт байна. Үүнд:

- 17.1.Цагдаагийн албаны сургалт нь мэргэшүүлэх, ур чадвар хөгжүүлэх, албан тушаалын буюу ажлын байрны сургалтаас бүрдэнэ.
17.1.1.Цагдаагийн алба хаагчийн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, үндсэн чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой сургалтыг мэргэшүүлэх сургалт
17.1.2.Цагдаагийн алба хаагчийн хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг дадал, ур чадварыг эзэмшүүлэх чиглэлээр зохион байгуулах сургалтыг ур чадвар хөгжүүлэх сургалт
17.1.3.Энэ хуулийн 17.1.1, 17.1.2-т зааснаас бусад сургалтыг албан тушаалын буюу ажлын байрны сургалт.
- 17.2.Цагдаагийн албанд анх томилогдох болон албан тушаал дэвших, өөрчлөгдөх тохиолдолд богино болон дунд хугацааны сургалтад хамруулна.

1.1.Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хүрээнд төрийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов.

Хуулийн төсөлд зааснаар, цагдаагийн албанд анх томилогдох болон албан тушаал дэвших, өөрчлөгдөх тохиолдолд албан хаагчийг 3 төрлийн сургалтад 2 тохиолдолд /анх томилогдох, албан тушаал өөрчлөгдөх/ хамруулахаар байна.

Хүснэгт 1. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Цагдаагийн байгууллага	Цагдаагийн албанд анх томилогдох тохиолдолд сургалтад хамруулах	<ol style="list-style-type: none">1. Цагдаагийн алба хаагчийн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, үндсэн чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой сургалтыг мэргэшүүлэх сургалтад хамруулах.2. Цагдаагийн алба хаагчийн хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг дадал, ур чадварыг эзэмшүүлэх чиглэлээр зохион байгуулах ур чадвар хөгжүүлэх сургалтад хамруулах.3. Албан тушаалын буюу ажлын байрны сургалтад хамруулах.

	Албан тушаал дэвших, өөрчлөгдөх тохиолдолд сургалтад хамруулах	<ol style="list-style-type: none"> 1. Цагдаагийн алба хаагчийн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, үндсэн чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой сургалтыг мэргэшүүлэх сургалтад хамруулах. 2. Цагдаагийн алба хаагчийн хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг дадал, ур чадварыг эзэмшүүлэх чиглэлээр зохион байгуулах ур чадвар хөгжүүлэх сургалтад хамруулах. 3. Албан тушаалын буюу ажлын байрны сургалтад хамруулах.
--	--	---

Сургалтын чиг үүрэгтэй холбоотой стандарт үйл ажиллагааны зардлын тооцоог хийхийн өмнө дараах зүйлийг анхаарахаар байна. Үүнд:

1. Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.3-т “Энэ хуулийн 17.1.1-д заасан сургалтын хөтөлбөр, агуулга, журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан тул цагдаагийн алба хаагчийн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, үндсэн чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой мэргэшүүлэх сургалт зохион байгуулахад үүсэх сургалтын хөтөлбөр, агуулга, журам боловсруулах стандарт ажиллагааг хасаж тооцох нь зүйтэй байна.

2. Цагдаагийн ерөнхий газар, Дотоодын цэргийн командлагчийн 2022 оны 01 дүгээр 11-ний өдрийн А/07 дугаар тушаалын хавсралт “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны албаны болон давтан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр”-т зааснаар, тус байгууллагад Ажлын байрны сургалтын хөтөлбөр /код-239/, Албан хаагчийн үргэлжилсэн сургалт /код-951/ тус тус хэрэгждэг байна. Сургалтын хөтөлбөрт, “Албан хаагч жилд 3.5-5.0 кредит цаг буюу 60-80 цагийн танхимын болон зайны цахим хэлбэрийн сургалтад хамрагдаж, мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн байна” гэж, Ажлын байрны сургалтын хөтөлбөр /код-239/-т шинээр болон ажиллаж байсан албан тушаалаас өөр албан тушаалд шилжсэн албан хаагчдад мэргэжлийн ур чадвар, дадал эзэмшүүлэхэд чиглэгдсэн ажлын байрны сургалтыг зохион байгуулахаар дор дурдсан зохицуулалтуудад тусгажээ.

- 239.1.Ажлын байрны сургалтын хөтөлбөр нь их, дээд болон ахлагчийн сургууль, дамжаа төгсөж, шинээр томилогдсон алба хаагчдад мэргэжлийн ур чадвар, дадал эзэмшүүлэхэд чиглэгдсэн ажлын байрны сургалтыг зохион байгуулах дэг горимыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- 239.5.1.Шинээр томилогдсон алба хаагчид 16-аас доошгүй долоо хоногийн ажлын байрны сургалтыг амжилттай төгссөн байх ёстой. Өөрийн ажиллаж байсан албан тушаалаас өөр мэргэшил шаардсан албан тушаалд шилжсэн алба хаагчид зориулсан сургалтын хугацааг тухайн алба хаагчийн ажлын гүйцэтгэл, туршлагын түвшингээс хамаарч 8-аас доошгүй 7 хоногоор явуулна.

- 239.5.2.Ажлын байрны сургалтын хөтөлбөрийн загварыг Цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын хэлтэс, Сургалтын төвөөс хамтран боловсруулна.

Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т заасан албан тушаалын буюу ажлын байрны сургалтыг Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.-т “Мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт явуулах журмыг цагдаагийн төв байгууллагын дарга батална.” гэж заасны дагуу уг сургалт хэрэгжиж байна. Иймд хуулийн төслийн 17.1.3-т заасан чиг үүрэг нь тус байгууллагад шинээр нэмэгдүүлсэн чиг үүрэг биш байх тул зардлын тооцооноос хасах нь үндэслэлтэй.

Дээрх үндэслэлээр цагдаагийн алба хаагчийг хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг дадал, ур чадвар эзэмшүүлэх чиглэлээр зохион байгуулах ур чадвар хөгжүүлэх сургалтад хамруулахад холбогдон гарах зардлыг цаашид тооцох болно.

Хүснэгт 2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Гүйцэтгэх байгууллага	Чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Цагдаагийн байгууллага	Цагдаагийн алба хаагчийн хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг дадал, ур чадварыг эзэмшүүлэх чиглэлээр зохион байгуулах ур чадвар хөгжүүлэх сургалтад хамруулах	Сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулах.
		Сургалтын хөтөлбөрийг хянуулж, батлуулах.
		Сургалтад оролцогчдод мэдээлэх.
		Сургалтыг биечлэн эсхүл цахимаар зохион байгуулах.

1.2.Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана. Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистикт тоон мэдээллийг тооцсон болно.

Хүснэгт 3. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
1	2	3	4	5

Цагдаагийн байгууллага	Сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулах	4800	1	4800
	Сургалтын хөтөлбөрийг хянуулж, батлуулах	960	1	960
	Сургалтад оролцогчдод мэдээлэх	60	12 ²	720
	Сургалтыг биечлэн эсхүл цахимаар зохион байгуулах	96000	1 ³	96000
Нийт				102,480

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1600 ажлын цаг буюу (1600 x 60) 96.000 минут ажиллана. Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 4. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
Цагдаагийн байгууллага	Сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулах	4800	96,000	0.05
	Сургалтын хөтөлбөрийг хянуулж, батлуулах	960	96,000	0.01
	Сургалтад оролцогчдод мэдээлэх	720	96,000	0.007
	Сургалтыг биечлэн эсхүл цахимаар зохион байгуулах	96,000	96,000	1
Нийт				1.067

Цагдаагийн алба хаагчийн хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэхэд зайлшгүй

² Уг сургалтыг сар бүр зохион байгуулна гэж тооцож тохиолдлын тоог 12 гэж үзэв.

³ Тасралтгүй хэрэгжүүлнэ гэж үзэж, тохиолдлын тоог 1 гэж тооцов.

шаардлагатай мэдлэг, дадал ур чадварыг эзэмшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулахад нийт 102,480 минут зарцуулах ба уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ **1.067** байна.

1.3. Гарах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Цагдаагийн байгууллагын Сургалт хариуцсан мэргэжилтний цалинг Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 11 дүгээр “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ” хавсралтыг үндэслэж тогтоолоо. Сургалт хариуцсан мэргэжилтний албан тушаал нь ТҮ-7 зэрэглэл буюу үндсэн цалингийн хэмжээ нь 1,264,000 төгрөг байна.⁴ Уг үндсэн цалин дээр нэмэгдэл, урамшууллыг нэмж тооцсон дүнгээр олговол зохих цалин нь дунджаар 1,769,000 төгрөг /үүнээс нийт суутгал болох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар зэргийг хасвал нэг сарын дундаж цалин 1,427,008 төгрөг/ байна. Үүнээс 1 жилд олговол зохих цалин нь 21,228,000 төгрөг, түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу сард 265,350 төгрөг буюу жилд 3,184,200 төгрөг болно. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар **24,412,200** төгрөг гэж тооцов. Энэ зардлыг **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 5. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Нийт хүний нөөцийн зардал (төгрөгөөр)
Цагдаагийн байгууллага	1.067	24,412,200	26,047,817

⁴ Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ (сард, төгрөгөөр)

ТҮ-12	1,418,000
ТҮ-11	1,351,000
ТҮ-10	1,286,000
ТҮ-9	1,225,000
ТҮ-8	1,114,000
ТҮ-7	1,053,000
ТҮ-6	1,003,000
ТҮ-5	912,000
ТҮ-4	868,000
ТҮ-3	827,000
ТҮ-2	788,000
ТҮ-1	750,000

1.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна. Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, хүний нөөцийн нэмэгдсэн ажлын ачаалалд ногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 6. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	1 жилд зарцуулах зардал (төгрөгөөр)
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид ногдох нийт зардал		5,395,434
Нийт албан хаагчид ногдох нийт зардал /1.067/		5,756,928

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 7. Нийт зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (хүний тоо)	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)	Материаллаг зардал (төгрөгөөр)	Нийт
Цагдаагийн байгууллага	1.067	26,047,817	5,756,928	31,804,745

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд цагдаагийн байгууллага хүний нөөцийн цалингийн зардалд нийт **26,047,817** төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд **5,756,928** төгрөг, нийт **31,804,745** /Гучин нэгэн сая найман зуун дөрвөн мянга долоон зуун дөчин тав/ төгрөгийн зардал үүсэхээр байна.

1.5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

1.5.1.Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;

Төрийн байгууллагын зардал тооцох хүрээнд, хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг тухайн төрийн байгууллага жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог “тохиолдлын тоо” гэж авч үздэг. Хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Цагдаагийн албанд анх томилогдох болон албан тушаал дэвших, өөрчлөгдөх тохиолдолд богино болон дунд хугацааны сургалтад хамруулна.” гэж заасан тул цагдаагийн албан хаагчид шаардлагатай мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах нь тасралтгүй хэрэгжүүлэх үүрэг байна.

1.5.2.Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;

Цагдаагийн байгууллагад сар бүр хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн хийгдэх тул мэдээллийг хүргүүлэх давтамжийг сард 1-с доош багасгах боломжгүй.

1.5.3.Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;

Тус хуулийн дагуу мэдээллийн агуулгыг бүрэн зөв хүргэх нь хуулийн үзэл баримтлалд нийцнэ гэж үзэж байна.

1.5.4.Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах талаарх сургалтыг цахимаар зохион байгуулах боломжтой байна. Тусгай хэрэгсэл хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, дадал, ур чадварыг эзэмшүүлэх сургалтыг танхимаар зохион байгуулах нь үр дүнтэй тул хуулийн төслийн 17.1.2-т заасан чиг үүргийг бүхэлд нь цахимаар хэрэгжүүлэх боломжгүй.

1.5.5.Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;

Хуулийн төслийн 17.4-т “Цагдаагийн алба хаагчийг мэргэшүүлэх, ур чадвар хөгжүүлэх, албан тушаалын буюу ажлын байрны сургалт явуулах төвийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулж болно.” гэж заасны дагуу, сургалтын төвийг бүсчлэн байгуулбал мэдээлэл хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой байна.

II. ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-т “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн.” гэж тус тус заасан. Мөн Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц” болон түүний нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр нэгдэн орсон.

Хуулийн төсөлд, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд “хохирогч”-ийг ялгаатай байдлаар тодорхойлсныг засаж хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хүрээнд хамгаалагдах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийн хохирогч нь гадаадын иргэн, хэл яриа, хараа, сонсголын бэрхшээлтэй бол өөрт нь ойлгомжтой хэлбэрээр мэдээлэл авах эрхтэй байх талаар тусгажээ.

Төрийн байгууллагын зардлын тооцоо

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Аргачлалын 4.4.6-д заасны дагуу төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээ буюу дараах дүрэм, журам, стандарт, кодчиллыг батлах чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг тус тооцоонд тусгаагүй. Үүнд:

- 3.1.3. “хувийн мэдээлэл” гэж Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.11-д заасан мэдээллийг.
- 10¹.3.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь хүүхэд бол хүүхэд, гэр бүл хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу яаралтай тусламж, үйлчилгээнд хамруулж болно.
- 12.4.Энэ хуулийн 12.1.4-т заасан үйлчилгээг Хууль зүйн туслалцааны хуульд заасан журмаар үзүүлнэ.
- 9.4.Хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

- 16.5.Энэ хуулийн 16.3.4-т заасан урамшуулал олгохтой холбогдсон харилцааг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулна.

Төрийн байгууллагаас гаргах зардлын тооцоонд нөлөөлөхгүй буюу үйл ажиллагааны зарчимтай холбоотой дараах зохицуулалтууд байна. Үүнд:

- 10¹.5. Хохирогчийн эрүүл мэндийн байдал, нас, хүйс, бэлгийн чиг хандлага, нийгмийн гарал, боловсролоор ялгаварлан гадуурхахыг хориглоно.
- 10¹.6.Зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд тухайн хэргийг шалгаж байгаа мөрдөгч, хяналт тавьж буй прокурорыг солихгүй.
- 10¹.8.Шүүгч, прокурор нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаас гадна дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:
 - 10¹.8.1.Хохирогчийн мэдээллийг нууцлах;
 - 10¹.8.2. Хамгаалах байранд байгаа хохирогчтой аль болох уулзахгүй байх;
 - 10¹.8.3. Шүүх хуралдаан болох байрны аюулгүй байдлын зураглалыг гаргах, шаардлагатай тохиолдолд шүүх хуралдааныг өөр байранд хийх санал гаргах.
- 12.5.Хохирогч хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй бол дохио, зангаа, тусгай, тэмдэгт ашиглан хэлмэрчийн тусламжтайгаар энэ зүйлийн 12.1-д заасан мэдээллийг авах эрхтэй.


Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд, тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.11 дүгээр заалтын “хохирогчийг” гэсний дараа “Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан хохирогчийг” гэж нэмсүгэй гэжээ. Хуулийн танилцуулгад дурдсанаар, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд “хохирогч”-ийг ялгаатай байдлаар тодорхойлсон нь хууль хэрэглээний хувьд төөрөгдөл үүсгэж байгааг арилгаж хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хүрээнд хамгаалагдах асуудлыг зөрчилгүй болгосон гэжээ. Иймд Гэрч, хохирогчийн хамгаалах тухай хууль болон тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалтад хамаарах зарим чиг үүргийг давхардуулахгүйн тулд уг зардлын тооцооноос хасаж тооцлоо. Үүнд:

- 10¹.2.Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй нөхцөл байдал, шинж тэмдэг илэрвэл эрсдэлийн үнэлгээ хийж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авна.⁵
- 10¹.4.Хохирогчийн аюулгүй байдлыг хангахдаа амь нас, эрүүл мэнд болон сэтгэл зүйн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангана.⁶
- 10¹.7.2.хохирогчийн эрсдэлийн түвшингээс хамаарч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээнд прокурорын тогтоол, шүүгчийн захирамжийг үндэслэн хамруулах;⁷

⁵ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйл.

⁶ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйл.

⁷ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйл.

- 
- 10¹.7.3. хохирогчийн амь бие, эрүүл мэндэд халдах талаар үндэслэлтэй мэдээлэл авагдсан тохиолдолд хамгаалалтад авах арга хэмжээг хохирогчийн зөвшөөрөл шаардахгүйгээр зохион байгуулах;⁸

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд, төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгт хамаарах дараах заалт байна. Үүнд:

- 10¹.1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй талаарх мэдээллийг тагнуул, цагдаагийн байгууллага хүлээн авсан даруйд хохирогчийг тогтоох арга хэмжээг авна.
- 10¹.7. Цагдаа, тагнуулын байгууллагын албан хаагч нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаас гадна дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:
 - 10¹.7.1. хохирогчид хуульд заасан эрх үүрэг, төрийн болон төрийн бус байгууллагаас түүнд үзүүлж болох тусламж, үйлчилгээний талаар болон шаардлагатай бусад мэдээллийг өгөх;
 - 10¹.7.4. хохирогч хамгаалалтын арга хэмжээнд хамрагдахаас сайн дураар татгалзсан бол энэ талаар баримтжуулах;
 - 10¹.7.5. оршин байгаа газраа соливол мэдэгдэхийг хохирогчид даалгах;
 - 10¹.7.6. гэмт хэрэгт холбогдсон этгээдийг сэжигтнээр баривчлан сулласан болон яллагдагчаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч, сулласан тухай мэдээллийг цаг алдалгүй өгөх;

2.1. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хүрээнд төрийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов. Зардалд нөлөөлөх зохицуулалтууд нь хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн байх тул стандарт үйл ажиллагаанд нэгтгэж тооцов.

⁸ Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх заалт.

Хүснэгт 8. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Цагдаагийн байгууллага	Хохирогчийн аюулгүй байдлыг хангах	1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй талаарх мэдээллийг тагнуул, цагдаагийн байгууллага хүлээн авсан даруйд хохирогчийг тогтоох арга хэмжээг авах;
		2. Хохирогчид хуульд заасан эрх үүрэг, төрийн болон төрийн бус байгууллагаас түүнд үзүүлж болох тусламж, үйлчилгээний талаар болон шаардлагатай бусад мэдээллийг өгөх;
		3. Хохирогч хамгаалалтын арга хэмжээнд хамрагдахаас сайн дураар татгалзсан бол энэ талаар баримтжуулах;
		4. Оршин байгаа газраа соливол мэдэгдэхийг хохирогчид даалгах;
		5. Гэмт хэрэгт холбогдсон этгээдийг сэжигтнээр баривчлан сулласан болон яллагдагчаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч, сулласан тухай мэдээллийг цаг алдалгүй өгөх;

2.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Цагдаа, тагнуулын байгууллагын албан хаагч нь хохирогчийн аюулгүй байдлыг хангахад дээр дурдсан стандарт үйл ажиллагааг тохиолдол бүрд хийх тул 1 тохиолдолд зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистикт тоон мэдээллийг тооцсон болно.

Хуулийн төслийн танилцуулгад дурдсанаар Монгол Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн хугацаанд Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан хүн худалдаалах 91 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнд 68 хүн холбогджээ. 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээлэлд улсын хэмжээнд хүн худалдаалах 27 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 6 хүн хохирогч болсон байна. Энэ төрлийн гэмт хэрэг цаашид үйлдэгдэх эсэхийг тодорхойлох боломжгүй тул хуулийн төсөлд дурдсан чиг үүргийг цагдаагийн байгууллагын тасралтгүй хэрэгжүүлэх үүрэг гэж үзэн тохиолдлын тоог стандарт үйл ажиллагаа бүрт 1 гэж үзэв.

Хүснэгт 9. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Цагдаагийн байгууллага	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй талаарх мэдээллийг тагнуул, цагдаагийн байгууллага хүлээн авсан даруйд хохирогчийг тогтоох арга хэмжээг авах	480	1	480
	Хохирогчид хуульд заасан эрх үүрэг, төрийн болон төрийн бус байгууллагаас түүнд үзүүлж болох тусламж, үйлчилгээний талаар болон шаардлагатай бусад мэдээллийг өгөх	60	1	60
	Хохирогч хамгаалалтын арга хэмжээнд хамрагдахаас сайн дураар татгалзсан бол энэ талаар баримтжуулах	120	1	120
	Оршин байгаа газраа соливол мэдэгдэхийг хохирогчид даалгах	60	1	60
	Гэмт хэрэгт холбогдсон этгээдийг сэжигтнээр баривчлан сулласан болон яллагдагчаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч, сулласан тухай мэдээллийг цаг алдалгүй өгөх	60	1	60
Нийт				780

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1600 ажлын цаг буюу (1600 x 60) 96.000 минут ажиллана. Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 10. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
Цагдаагийн байгууллага	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй талаарх мэдээллийг тагнуул, цагдаагийн байгууллага хүлээн авсан даруйд хохирогчийг тогтоох арга хэмжээг авах	480	96,000	0.005
	Хохирогчид хуульд заасан эрх үүрэг, төрийн болон төрийн бус байгууллагаас түүнд үзүүлж болох тусламж, үйлчилгээний талаар болон шаардлагатай бусад мэдээллийг өгөх	60	96,000	0.0006
	Хохирогч хамгаалалтын арга хэмжээнд хамрагдахаас сайн дураар татгалзсан бол энэ талаар баримтжуулах	120	96,000	0.001
	Оршин байгаа газраа соливол мэдэгдэхийг хохирогчид даалгах	60	96,000	0.0006
	Гэмт хэрэгт холбогдсон этгээдийг сэжигтнээр баривчлан сулласан болон яллагдагчаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч, сулласан тухай мэдээллийг цаг алдалгүй өгөх	60	96,000	0.0006
Нийт				0.0078

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар шинээр нэмэгдсэн чиг үүргүүдийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн 1 тохиолдолд хэрэгжүүлэхэд нийт **780 минут** зарцуулах ба уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ **0.0078** буюу 1-с бага байна.

2.3. Гаргах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Цагдаагийн байгууллагын албан хаагчийн цалинг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 26 дугаар тогтоолын хавсралт “Төрийн тусгай албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалт”, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”-г үндэслэж тогтоолоо. Чиг үүргийг хэрэгжүүлэх буюу гүйцэтгэх албан тушаалыг ТТ-7 зэрэглэл буюу үндсэн цалингийн хэмжээ нь 1,541,000 төгрөг байна.⁹ Уг үндсэн цалин дээр нэмэгдэл, урамшууллыг нэмж тооцсон дүнгээр олговол зохих цалин нь дунджаар 2,157,400 төгрөг /үүнээс нийт суутгал болох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг хасаж нэг сарын дундаж цалин 1,738,369 төгрөг/ байна. Үүнээс 1 жилд олговол зохих цалин нь 25,888,800 төгрөг, түүнд ногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу сард 269,675 төгрөг буюу жилд 3,236,100 төгрөг болно. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь жилд дунджаар **29,124,900** төгрөг гэж тооцов.

Энэ зардлаа дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна. Дээр дурдсанчлан, хуулийн төсөлд шинээр нэмэгдсэн чиг үүргүүдийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн хэрэгцээ нь 1-с бага буюу 0.0078 тул энэ хугацаанд тохирох цалингийн зардлыг тооцоолно.

Хүснэгт 11. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Нийт хүний нөөцийн зардал (төгрөгөөр)
Цагдаагийн байгууллага	0.0078	29,124,900	227,174

⁹ Ажлын албаны албан тушаалын цалингийн хэмжээ (сард, төгрөгөөр)

ТТ-1	2,065,000
ТТ-2	1,967,000
ТТ-3	1,873,000
ТТ-4	1,784,000
ТТ-5	1,698,000
ТТ-6	1,618,000
ТТ-7	1,541,000
ТТ-8	1,467,000
ТТ-9	1,398,000
ТТ-10	1,331,000
ТТ-11	1,210,000
ТТ-12	1,100,000

2.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, хүний нөөцийн нэмэгдсэн ажлын ачаалалд ногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 12. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал


Зардлын төрөл	Зардлын нэр	1 жилд зарцуулах зардал (төгрөгөөр)
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид ногдох нийт зардал		5,395,434
Нийт албан хаагчид ногдох нийт зардал /0.0078/		420,834

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 13. Нийт зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал (хүний тоо)	Хүний нөөцийн зардал (төгрөгөөр)	Материаллаг зардал (төгрөгөөр)	Нийт
Цагдаагийн байгууллага	1.067	227,174	420,834	648,008

Цагдаагийн байгууллага хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах хүний нөөцийн цалингийн зардалд нийт **227,174** төгрөг, хүний нөөцийн



хангамжийн материаллаг зардалд **420,834** төгрөг, нийт **648,008** /Зургаан зуун дөчин найман мянга найман төгрөг/ төгрөгийн зардал үүсэхээр байна.

2.5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

2.5.1.Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;

Төрийн байгууллагын зардал тооцох хүрээнд, хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг тухайн төрийн байгууллага жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог “тохиолдлын тоо” гэж авч үздэг. Уг зардлын тооцоонд хүн худалдаалах гэмт хэргийн тохиолдлын тоог 1-р тооцож тодорхойлсон ба тухайн жилд хүн худалдаалах гэмт хэргийн тоо хэд бүртгэгдэхээс тохиолдлын тоо шууд хамааралтай байна.

2.5.2.Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;

Хуулийн төсөлд заасан нэмэлт, өөрчлөлтүүд нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн тул стандарт үйл ажиллагааг гүйцэтгэх давтамжийг багасгах боломжгүй.

2.5.3.Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;

Тус хуулийн дагуу мэдээллийн агуулгыг бүрэн зөв хүргэх нь хуулийн үзэл баримтлалд нийцнэ гэж үзэж байна.

III. ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.8-д “Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.” гэж тус тус заасан байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан, иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хуульд ил тод, нээлттэй байхаар заагаагүй бөгөөд нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг албаны нууцад хамааруулахгүй байх буюу нууцад хамааруулах мэдээллийн шалгуур үзүүлэлтийг тогтоож, албаны мэдээллийг тухайн байгууллагын дарга баталж байгааг өөрчилж, тагнуулын байгууллагын дарга баталдаг байхаар тусгажээ.

Төрийн байгууллагын зардлын тооцоо

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Аргачлалын 4.4.6-д заасны дагуу төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээ буюу дараах дүрэм, журам, стандарт, кодчиллыг батлах чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг тус тооцоонд тусгаагүй. Үүнд:

- 5.1.2."албаны нууц" гэж тухайн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр албаны нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах, эсхүл салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг;
- 14.1.Албаны нууцад дараах шаардлагыг хангасан мэдээллийг хамааруулна:
 - 14.1.1.тухайн мэдээлэл нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүний эрх, эрх чөлөө, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн байх;

14.1.2. тухайн мэдээллийг ил тод, нээлттэй болгох, бусдад дамжуулах, өгөх нь хуулиар хамгаалсан ашиг сонирхолд хохирол учрахыг тогтоосон байх;

14.1.3. энэ хуулийн 14.1.2-т заасан учрах хохирол нь олон нийтийн мэдээлэлтэй байх ашиг сонирхлоос давахаар байвал.

- 14.2. Энэ хуулийн 14.1-д заасан үндэслэлээр албаны нууцад хамааруулсан хэдий ч тухайн мэдээлэл нь төрийн байгууллага, бусад хуулийн этгээд, албан тушаалтны хууль бус үйлдлийг нуух зорилготой бол мэдээллийг албаны нууцад хамааруулж тогтоохыг хориглоно.
- 14.3. Албаны нууцад хамаарах мэдээллийг Тагнуулын байгууллагын дарга батална.

Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд, төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгт хамаарах /Хүснэгт.1-д заасан/ дараах заалт байна. Үүнд:

- 14.4. Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ил болгох мэдээлэл байгаа эсэхэд багтаан дүн шинжилгээг жил бүрийн эхний улиралд хийнэ.

3.1. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хүрээнд төрийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов. Мөн албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ил болгох мэдээлэл байгаа эсэхийг дүн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэхэд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Төрийн болон албаны нууцыг ил болгох үндэслэл, журам, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5-д заасныг баримтлах тул төрийн байгууллага болон хуулийн этгээдийн гүйцэтгэх стандарт үйл ажиллагаа адил байна.

Хүснэгт 14. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
	14.4. Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь албаны нууцад	1. Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт гаргах.

Төрийн байгууллага/ Хуулийн этгээд	хамаарах мэдээллийн жагсаалтад ил болгох мэдээлэл байгаа эсэхэд багтаан дүн шинжилгээг жил бүрийн эхний улиралд хийнэ.	2. Мэдээллийн жагсаалтыг батлах.
		3. Албаны нууцад хамааруулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх.
		4. Албан нууцад хамаарах мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн тухай дүгнэлт гаргах.

3.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана. Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистикт тоон мэдээллийг тооцсон болно. Хуулийн төсөлд заасны дагуу стандарт үйл ажиллагааг тухайн жилд нэг удаа гүйцэтгэх тул тохиолдлын тоог 1 гэж үзэв.

Хүснэгт 15. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Төрийн байгууллага/ Хуулийн этгээд	Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт гаргах.	480	1	480
	Мэдээллийн жагсаалтыг батлах.	480	1	480
	Албаны нууцад хамааруулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх.	480	1	480
	Албан нууцад хамаарах мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн тухай дүгнэлт гаргах.	120	1	120
Нийт				1560

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 х 8) 1600 ажлын цаг буюу (1600 х 60) 96.000 минут ажиллана. Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.


Хүснэгт 16. Нэг байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
Төрийн байгууллага/ Хуулийн этгээд	Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт гаргах.	480	96,000	0.005
	Мэдээллийн жагсаалтыг батлах.	480	96,000	0.005
	Албаны нууцад хамааруулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх.	480	96,000	0.005
	Албан нууцад хамаарах мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн тухай дүгнэлт гаргах.	120	96,000	0.001
Нийт				0.016

Төрийн байгууллага болон хуулийн этгээдэд албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ил болгох мэдээлэл байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ нэг байгууллагад 0.016 буюу 1-с бага байна. Өөрөөр хэлбэл, төсөлд заасан чиг үүргийг гүйцэтгэхэд 3.25 өдрийн хугацаа зарцуулагдахаар байна.

3.3. Үр дүнг тооцох

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.-т “Албаны нууцтай танилцах ажил, албан тушаалд төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн удирдлагын шийдвэрээр тухайн нууцтай танилцах эрх олгогдсон албан тушаалтныг ажиллуулах бөгөөд тэдгээр нь сонгогдсон, эсхүл томилогдсон даруй нууцыг задруулахгүй байх баталгаа гаргана” гэж, 30.4.-т “Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь төрийн болон албаны нууцтай холбоотой ажлын цар хүрээ, ачааллаас хамааран тэдгээрийн удирдлагад шууд захирагдах төрийн болон албаны нууцыг хамгаалах нэгж, эсхүл ажилтантай байна.” гэж, 29.2.-т “Нууц хамгаалах ажилтанд харьцаж байгаа нууцын зэрэглэл, нууцтай ажилласан хугацааг харгалзан Засгийн газраас тогтоосон журмын дагуу цалингийн нэмэгдэл олгоно”, 28.1.1.-т Төрийн болон албаны нууцыг хамгаалах ажилтан нь “Төрийн болон албаны нууцыг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нууц албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулж хэрэгжүүлэх” гэж тус тус заасан.



Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу нууц хамгаалах ажилтан нь төсөлд заасан /албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ил болгох мэдээлэл байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх/ чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй байна. Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ил болгох мэдээллийн дүн шинжилгээг жилд нэг удаа гүйцэтгэхэд 3.25 өдрийг зарцуулах тул төрийн байгууллага, хуулийн этгээдүүд шинээр орон тоо нэмэгдүүлэх шаардлагагүй буюу одоогийн бүтэц, орон тоонд тулгуурлан чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой.

IV. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Төрийн байгууллагын зардлын тооцоо

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд, төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох дараах заалтууд байна. Үүнд:

Хүснэгт 17. Зардалд нөлөөлөх зүйл заалт

Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт
190.5.5.Сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх эмнэлгийн байгууллага нь харуул хамгаалалтын нэгж, харуул хамгаалалтын ажилтантай байна.	190.5.6.Сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ авагдсан этгээдийг арга хэмжээнээс чөлөөлөхөд асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл садангийн хүнгүй, хүлээн авахаас татгалзсан тохиолдолд Шүүх хэвтэн эмчлүүлж буй эмнэлгийн байгууллагын энгийн тасагт шилжүүлж болно.

4.1.Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно.

Хүснэгт 18. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
-----------------------	----------------------	------------------------

СЭМҮТ	190.5.5.Сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх эмнэлгийн байгууллага нь харуул хамгаалалтын нэгж, харуул хамгаалалтын ажилтантай байна.	<ul style="list-style-type: none"> - Шүүхийн шийтгэх тогтоол, шинжээч томилох тогтоол, холбогдох бусад баримт бичиг нь эмчлүүлэгчийн овог, нэр, регистрийн дугаар, фото зурагтай тохирч буй эсэхийг тулган шалгах ; - Эмчлүүлэгчийн биед үзлэг хийж, илэрсэн гэмтэл, шарх, сорви, онцлог содон тэмдэг /"шивээс, мэнгэ" гэх мэт/ зэргийг дэлгэрэнгүй тэмдэглэж авах; - Эмчлүүлэгчийн өмссөн хувцас, авч яваа бусад эд зүйлд үзлэг хийж, эмнэлэгт нэвтрүүлэхийг хориглосон эд зүйлсийг хураан авч гэр бүл, төрөл садангийн хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон өвчтнийг хүргэж ирсэн албан тушаалтанд хүлээлгэн өгч, энэ тухай тэмдэглэл үйлдэн, байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулж баталгаажуулах; - Эмнэлгийн захиргаа болон эрхлэгч эмчийн зөвшөөрөлгүйгээр хяналт тавьж буй прокурор, эмнэлгийн ажилчдаас бусад гадны хүнийг албадан эмчлэх эмнэлгийн байранд нэвтрүүлэхгүй байх; - Албадан эмчлэх эмнэлэгт нэвтрэх, гадагш гарах иргэдийн биеийн байцаалт, зөвшөөрлийн хуудсыг шалгаж, шаардлагатай тохиолдолд биед үзлэг хийх; - Эмчлүүлэгчийг баталсан хуваарийн дагуу эмнэлгийн гадна орчин /эмнэлгийн хашаан дотор/-д харуул хамгаалалтын ажилтан, асрагчийн хяналт дор салхилуулах үед хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, хянан харгалзах; - Хамгаалалтын ажилтан нь эмчлүүлэгч амиа хорлох, биедээ гэмтэл учруулах үйлдэл хийхийг завдах, өөр хоорондоо болон эмч, сувилагч, асрагчтай маргалдах, зодолдох, үймээн дэгдээх зэргийг таслан зогсоох арга хэмжээ авах; - Хамгаалалтын ажилтан нь ээлж хүлээлцэх бүрт эмчлүүлэгчийн бие, өрөө тасалгаа, ор, шүүгээ болон бусад хувийн эд зүйлсэд сувилагч, асрагч нарын хамт үзлэг хийж, хориглосон эд зүйлс илэрвэл хураан авч устгах ба энэ тухай тэмдэглэл хөтөлнө. - Эмчлүүлэгчдээс гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хэргийн газрыг хамгаалалтад авч, нэн даруй Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, цагдаагийн байгууллага, эмнэлгийн захиргаанд мэдэгдэнэ.
-------	--	---

4.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана. Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистикт тоон мэдээллийг тооцсон болно.

Тухайлсан харилцааг зохицуулсан журам боловсруулж, батлах процесс нь нэг удаа гүйцэтгэгдэх тул тохиолдлын тоо нь хэмжигдэх боломжтой буюу стандарт үйл ажиллагаа бүрд 1 байна.

Хүснэгт 19. Стандарт үйл ажиллагаа холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

№	Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
1.	СЭМҮТ	Шүүхийн шийтгэх тогтоол, шинжээч томилох тогтоол, холбогдох бусад баримт бичиг нь эмчлүүлэгчийн овог, нэр, регистрийн дугаар, фото зурагтай тохирч буй эсэхийг тулган шалгах;	10700	1 ¹⁰	10700
2.		Эмчлүүлэгчийн биед үзлэг хийж, илэрсэн гэмтэл, шарх, сорви, онцлог содон тэмдэг /"шивээс, мэнгэ" гэх мэт/ зэргийг дэлгэрэнгүй тэмдэглэж авах;	10700	1	10700
3.		Эмчлүүлэгчийн өмссөн хувцас, авч яваа бусад эд зүйлд үзлэг хийж, эмнэлэгт нэвтрүүлэхийг хориглосон эд зүйлсийг хураан авч гэр бүл, төрөл садангийн хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон өвчтнийг хүргэж ирсэн албан тушаалтанд хүлээлгэн өгч, энэ тухай	11500	1	11500

¹⁰ Засгийн газрын 59 дүгээр тогтоолын хавсралт аргачлалын 4.4.3.2-д зааснаар үргэлжилсэн шинжтэй, тасралтгүй хийгдэх ажил, үйлчилгээг тогтоох боломжгүй тохиолдлын тоонд хамааруулна. Тухайлбал, харуул хамгаалалтын ажилтаны хийх үйл ажиллагаа нь хэдэн жилээр ч үргэлжлүүлэн хэрэгжүүлж болох бөгөөд энэ нөхцөлд шаардагдах хүний нөөцийг шууд баримжаалж тооцно. Иймд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн харуул хамгаалалтын ажилтаны чиг үүргийн тохиолдлын тоог 1 гэж үзэв.

		тэмдэглэл үйлдэн, байлцсан хүмүүсээр гарын үсэг зуруулж баталгаажуулах;			
4.		Эмнэлгийн захиргаа болон эрхлэгч эмчийн зөвшөөрөлгүйгээр хяналт тавьж буй прокурор, эмнэлгийн ажилчдаас бусад гадны хүнийг албадан эмчлэх эмнэлгийн байранд нэвтрүүлэхгүй байх;	9500	1	9500
5.		Албадан эмчлэх эмнэлэгт нэвтрэх, гадагш гарах иргэдийн биеийн байцаалт, зөвшөөрлийн хуудсыг шалгаж, шаардлагатай тохиолдолд биед үзлэг хийх;	8700	1	8700
6.		Эмчлүүлэгчийг баталсан хуваарийн дагуу эмнэлгийн гадна орчин /эмнэлгийн хашаан дотор/-д харуул хамгаалалтын ажилтан, асрагчийн хяналт дор салхилуулах үед хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, хянан харгалзах;	12000	1	12000
7.		Хамгаалалтын ажилтан нь эмчлүүлэгч амиа хорлох, биедээ гэмтэл учруулах үйлдэл хийхийг завдах, өөр хоорондоо болон эмч, сувилагч, асрагчтай маргалдах, зодолдох, үймээн дэгдээх зэргийг таслан зогсоох арга хэмжээ авах;	9500	1	9500
8.		Хамгаалалтын ажилтан нь ээлж хүлээлцэх бүрт эмчлүүлэгчийн бие, өрөө тасалгаа, ор, шүүгээ болон бусад хувийн эд зүйлсэд сувилагч, асрагч нарын хамт үзлэг хийж, хориглосон эд зүйлс илэрвэл хураан авч устгах ба энэ тухай тэмдэглэл хөтөлнө.	10700	1	10700

9.		Эмчлүүлэгчдээс гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хэргийн газрыг хамгаалалтад авч, нэн даруй Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, цагдаагийн байгууллага, эмнэлгийн захиргаанд мэдэгдэнэ.	12700	1	12700
Нийт					96000

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1600 ажлын цаг буюу (1600 x 60) 96.000 минут ажиллана.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхэд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журмын 5.1-т "Хамгаалалтын нэг ээлжинд 3-аас доошгүй хамгаалалтын ажилтан үүрэг гүйцэтгэхээр зохион байгуулна." гэж заасан байна. Энэхүү журмыг баримтлан харуул хамгаалалтын ажилтаныг 2 ээлжээр, 6 ажилтантай байхаар тооцоолов. Иймд 6 хүний жилд царцуулагдах (96.000 x 6) 576.000 минут шаардагдахаар байна. Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 20. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

№	Нэгж	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
1.	СЭМҮТ	190.5.5.Сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх эмнэлгийн байгууллага нь харуул хамгаалалтын нэгж, харуул хамгаалалтын ажилтантай байна.	576.000	96.000	6

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь харуул хамгаалалтын нэгж, харуул хамгаалалтын ажилтны шийдвэрийн төсөл боловсруулж, батлуулахад 576.000 минут

буюу ажлын 20 өдөр зарцуулахаар байгаа нь уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд 6 ажилтан шаардлагатай гэж үзэв.

4.3.Гарах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалтны цалингийн хэмжээг үндэслэвэл Төрийн захиргааны байгууллагын нэг албан хаагчийн сарын дундаж цалин нь 1,365,400 төгрөг байна.¹¹ Эндээс жилийн дундаж цалинг нь 16,384,800 төгрөг, түүнд оногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээг 1,884,252 төгрөг, нийт **18,269,052** төгрөг гэж тооцов. Энэ зардлаа дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 21. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

№	Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал
1.	Үндэсний зөвлөл, түүний ажлын алба	6	18,269,052	109,614,312

4.4.Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал,

¹¹ Албан тушаалын зэрэглэлээр тогтоосон цалингийн хэмжээ (сард, төгрөгөөр)

ТҮ-1	1,703,000
ТҮ-2	1,621,000
ТҮ-3	1,544,000
ТҮ-4	1,471,000
ТҮ-5	1,400,000
ТҮ-6	1,334,000
ТҮ-7	1,271,000
ТҮ-8	1,210,000
ТҮ-9	1,100,000
ТҮ-10	1,000,000

техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, хүний нөөцийн нэмэгдсэн ажлын ачаалалд ногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 22. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	Зардал /төгрөгөөр/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1,411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид оногдох		5,395,434

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 23. Нийт зардал

№	Нэгж	Хүний нөөцийн зардал	Материаллаг зардал	Нийт
1.	Үндэсний зөвлөл, түүний ажлын алба	109,614,312	32,372,604	141,986,916


Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн харуул хамгаалалтын нэгжийн хүний нөөцийн цалингийн зардалд **нийт 141,986,916** төгрөгийн зардал үүсэхээр байна.

4.5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

4.5.1.Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;

Хуулийн төслийн 190.5.5 дах хэсэгт Сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх эмнэлгийн байгууллага нь харуул хамгаалалтын нэгж, харуул хамгаалалтын ажилтантай байхаар заасан. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхэд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журмын 5.1-т “Хамгаалалтын нэг ээлжинд 3-аас доошгүй хамгаалалтын ажилтан үүрэг



гүйцэтгэхээр зохион байгуулна." гэж заасан байна. Энэхүү журмыг баримтлан харуул хамгаалалтын ажилтныг 2 ээлжээр, 6 ажилтантай байхаар тооцоолсон.

Харуул хамгаалалтын ажилтны хийх үйл ажиллагаа нь хэдэн жилээр ч үргэлжлүүлэн хэрэгжүүлж болох бөгөөд энэ нөхцөлд шаардагдах хүний нөөцийг шууд баримжаалж тооцсон. Иймд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн харуул хамгаалалтын ажилтны чиг үүргийн тохиолдлын тоог 1 гэж үзэв. Үүнээс үзвэл харуул хамгаалалтын чиг үүрэг нь үргэлжлэх шинжтэй үйл ажиллагаа тул уг зардлын тооцооны хүрээнд үүнээс бууруулах боломжгүй юм.

4.5.2.Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;

Хуулийн төслийн 190.5.5 дах хэсгийн харуул хамгаалалтын ажилтанд хамаарах чиг үүргийг Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхэд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журмын дагуу эмчлүүлэгчдээс гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хэргийн газрыг хамгаалалтад авч, нэн даруй Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, цагдаагийн байгууллага, эмнэлгийн захиргаанд мэдэгдэнэ гэж тодорхойлсон. Уг чиг үүргийн давтамж нь үргэлжилсэн шинжтэй, тодорхойлох боломжгүй тул 1 гэж авч үзсэн. Иймд мэдээллийг тухай бүр хүргүүлэх нь үр дүнтэй байх тул давтамжийг багасгах чиглэл баримтлах нь зохимжгүй.

4.5.3.Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;

Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс мэдээллийн агуулгыг хязгаарлалгүйгээр мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангахад чиглэх нь зүйтэй.

4.5.4.Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;


Эмчлүүлэгчдээс гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хэргийн газрыг хамгаалалтад авч, нэн даруй Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, цагдаагийн байгууллага, эмнэлгийн захиргаанд мэдэгдэхэд яаралтай шинжтэй тул цахимаар хүргүүлэх боломжгүй байна.

4.5.5.Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, цагдаагийн байгууллага, эмнэлгийн захиргаанд мэдэгдэхэд зайлшгүй шаардлагатай тул мэдээлэл хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжгүй юм.

Хуулийн төсөлд зардлын тооцоо хийх нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцох зорилготой байдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төрд учрах зардлыг урьдчилан тодорхойлох, цаашид ачааллыг аль болох багасгах санал боловсруулах зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд харуул хамгаалалтын нэгж, харуул хамгаалалтын ажилтны хувьд Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхэд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журмын 5.1-т "Хамгаалалтын нэг ээлжинд 3-аас доошгүй хамгаалалтын ажилтан үүрэг гүйцэтгэхээр зохион байгуулна." гэж заасан байна. Энэхүү журмыг баримтлан харуул хамгаалалтын ажилтаныг 2 ээлжээр, 6 ажилтантай байхаар тооцоолон хүний нөөцийн зардалд 109,614,312 төгрөг, материаллаг зардалд 32,372,604 төгрөг, нийт **141,986,916** төгрөгийн зардал төрд үүсэхээр байна.



Хуулийн төсөлд хамаарах харуул хамгаалалтын ажилтны хийх үйл ажиллагаа нь хэдэн жилээр ч үргэлжлүүлэн хэрэгжүүлж болох бөгөөд энэ нөхцөлд шаардагдах хүний нөөцийн чиг үүрэг нь нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаа тул уг зардлын тооцооны хүрээнд үүнээс бууруулах боломжгүй юм. Мөн Хуулийн төслийн 190.5.5 дах хэсгийн харуул хамгаалалтын ажилтанд хамаарах чиг үүргийг Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхэд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журмын дагуу эмчлүүлэгчдээс гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хэргийн газрыг хамгаалалтад авч, нэн даруй Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, цагдаагийн байгууллага, эмнэлгийн захиргаанд мэдэгдэнэ гэж тодорхойлсон. Уг чиг үүргийн давтамж нь үргэлжилсэн шинжтэй, тодорхойлох боломжгүй тул мэдээллийг тухай бүр хүргүүлэх нь үр дүнтэй байх учир давтамжийг багасгах чиглэл баримтлах нь зохимжгүй. Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс мэдээллийн агуулгыг хязгаарлалгүйгээр мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангахад чиглэх нь зүйтэй. Эмчлүүлэгчдээс гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хэргийн газрыг хамгаалалтад авч, нэн даруй Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, цагдаагийн байгууллага, эмнэлгийн захиргаанд мэдэгдэхэд яаралтай шинжтэй тул цахимаар хүргүүлэх боломжгүй байна. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, цагдаагийн байгууллага, эмнэлгийн захиргаанд мэдэгдэхэд зайлшгүй шаардлагатай тул мэдээлэл хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжгүй юм.

V.ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

Хуулийн төслийн 7.5 дах хэсгийн 8-д “Сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлэх албадлагын арга хэмжээ нь ердийн болон тусгай тасагтай байна” гэж заасан байна. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх түүнд хяналт тавих журамд тодорхойлсны дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв эмчилдэг. Уг журмын 2.1.-т “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх этгээдийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн хүлээн авах тасагт эмч, сувилагч хүлээн авч тусгай бүртгэл хөтөлж, өвчний түүх нээн хаягийн хэсгийг бөглөнө.” гэж тодорхойлсон байна. Үүнийг тус эмнэлгийн холбогдох мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагын хэсэг буюу шигтгээ 1-д дурдлаа.

Шигтгээ 1

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн холбогдох мэргэжилтэн

Албадан эмчилгээнд эмчлүүлж буй гэмт этгээдүүд нь хэргийн нөхцөлөөс хамааран шүүхийн шийдвэрийн дагуу хөнгөн гэмт хэрэг хийсэн бол ердийн буюу энгийн иргэдтэй хамт эмчлүүлдэг. Энэ нь гэмт хэрэг хийсэн хүн энгийн иргэдтэй хамт эмчлүүлснээр тав тухын алдагдуулах зэрэг тодорхой асуудлууд үүсэж эхэлсэн. Харин Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиник нь тусгай тасаг буюу хүнд гэмт хэрэг үйлдсэн хүмүүс харуул хамгаалалтын дор шүүхийн шийдвэрийн дагуу эмчлүүлдэг.

Үүнээс үзвэл тус эмнэлгийн хүрээнд гэмт хэрэг үйлдсэн хүний албадан эмчилгээг тусгай болон ердийн тасгийг тус тусад нь байгуулах зайлшгүй хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Хуулийн төслийн 7.5 дугаар зүйлийн 8.1-т “ердийн тасагт хөнгөн гэмт хэрэг үйлдсэн, сэтгэцийн эрүүл мэндийн байдал нь тогтворжсон боловч хэвтэн эмчлэх шаардлагатай хүнийг ердийн хамгаалалт бүхий нөхцөлд албадан эмчлэх арга хэмжээ хамаарна.” мөн төслийн 8.2-д “тусгай тасагт эмчлэх гэдэгт гэмт этгээдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарыг харгалзан өндөржүүлсэн хамгаалалт бүхий албадан эмчлэх арга хэмжээг хамаарна.” гэж тус тус тодорхойлсон байна. Засгийн газрын 59 дүгээр тогтоолын хавсралт аргачлалын гарын авлагад Зардлын тооцоо нь үүрэг хүлээсэн байгууллага нэг бүрийг тодорхойлж, түүнийг гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн тодорхойлж хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулж хуулийн төслийн хүрээнд шинээр бий болох зардлыг авч үздэг. Гэвч уг зохицуулалтууд нь сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмнэлгийн бүтэц, дотоод зохион байгуулалттай хамааралтай юм. Мөн Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй 144 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэр гарсан¹² байгаа нь уг харилцаа өмнө нь үүсэж Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь эмчилж байсан зэргээс харахад тус зохицуулалтуудын хүрээнд төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах төрд үүсэх зардлын тооцоонд хамааралгүй байна.

¹² Монгол Улс дах хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ ба хүний эрхийн асуудал” 87 дахь тал.

Хүснэгт 24. Харьцуулалт

Эрүүгийн хууль	Эрүүгийн хуулийн 7.4 дэх хэсгийн 9-д Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл, согтуурах, мансуурах донтой байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно.
Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	7.8.3 ¹³ .Донтох эмгэг судлалын тасагт албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэх хугацаа 12 сар хүртэл байна.

Эрүүгийн хуульд донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулахдаа хугацаа тогтоож өгөөгүй нь тухайн өвчтөн хэдэн жилээр ч эмчлүүлэх боломжтойг харуулж байна. Үүнийг хуулийн төслийн 7.8.3-т “Донтох эмгэг судлалын тасагт албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэх хугацаа **12 сар** хүртэл байна” гэж хугацааг тодорхойлсон байгаа нь төрөөс гарах зардлыг бууруулсан зохицуулалт болсон байна.

¹³ Хуулийн төсөлд дэд хэсгийн 7.7-г хоёр удаа давхардуулсан байх тул уг судалгаанд албадан эмчилгээ аюулгүй байдлын арга хэмжээний хугацааг 7.8 дахь хэсгээр тодорхойлов.

VI. АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн “тайлагнах;” гэснийг “тайлагнаж, олон нийтэд мэдээлэх;” гэж, 9.1.5 дахь заалтын “өгөх”, гэснийг “өгч, олон нийтэд мэдээлэх гэж,” тус тус өөрчлөлт оруулж байна.

Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Төрийн байгууллагын бүтэц бүрэлдэхүүн, зардал, ажлын ачаалалд нөлөө үзүүлэх боломжтой зохицуулалтыг сонгож авахдаа Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд зааснаар Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтыг сонгон авлаа.

6.1. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;

2. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;

3. Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах;

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хүрээнд төрийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов.

Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын зардлын тооцооллын хийхдээ “агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг УИХ-д тайлагнаж...” гэсэн чиг үүрэг одоо хэрэгжиж буй хуульд байгаа тул “...олон нийтэд мэдээлэх”-д зардлыг тооцов. Мэдээллийн олон нийтэд хүргэхдээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8-д “Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг олон нийтэд хүргэхдээ цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглана¹⁴.” гэснийг болон 2022 оны Шүүхийн ерөнхий зөвлөлийн 343 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журам”-д заасан үйл ажиллагаатай дүйцүүлэн тогтоов.

¹⁴ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390263044601>

Хүснэгт 25. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

№	Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
1.	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	6.1.4. агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг жил бүр Улсын Их Хуралд тайлагнаж, олон нийтэд мэдээлэх;	Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний тайланг байгууллагын цахим хуудаст нийтэд ил тод байршуулах;
2.	Аймаг, нийслэлийн засаг дарга	15.7. Аймаг, нийслэлийн Засаг дарга агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг тайлагнаж, олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий албыг байгуулж ажиллуулна.	Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний тайланг цахим хуудаст нийтэд нээлттэй, ил тод байршуулах;

6.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана. Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистикт тоон мэдээллийг тооцсон болно.

Хүснэгт 26. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

№	Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
1.	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний тайланг байгууллагын цахим хуудаст нийтэд ил тод байршуулах;	120	1	120
Нийт					120

Хүснэгт 27. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

№	Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
1.	Аймаг, нийслэлийн засаг дарга;	Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний тайланг цахим хуудаст нийтэд	120	12	1440

		нээлттэй, ил тод байршуулах;			
Нийт					1440

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200x8) 1600 ажлын цаг буюу (1600x60) 96.000 минут ажиллана. Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 28. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

№	Нэгж	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
1.	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хэвлэл мэдээллийн алба	Мэдээллийг олон нийтэд цахимаар хүргэх;	120	96,000	0.00125
Нийт					0.00125

Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжилтийн тайланг олон нийтэд мэдээлэхэд 120 минут зарцуулах ба тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн хэрэгцээ 0.00125 буюу нэмэлтээр ажлын байр үүсгэх шаардлагагүй байна.

Хүснэгт 29. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

№	Нэгж	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
1.	Аймаг, нийслэлийн засаг даргын байгуулсан ажлын алба	Мэдээллийг олон нийтэд цахимаар хүргэх;	1440	96,000	0.15
Нийт					0.15

Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг тайлагнаж, олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн хэрэгцээ 0.15 буюу нэмэлтээр ажлын байр үүсэх шаардлагагүй.

6.3. Гарах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төсөлд улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Дээрх хоёр чиг үүргийг хэрэгжүүлэх хүний нөөцийг тодорхойлоход 0.15 буюу хүний нөөц ачаалал гарахгүй байх тул цалингийн хэмжээг тооцох шаардлагагүй.


6.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна. Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, хүний нөөцийн нэмэгдсэн ажлын ачаалалд ногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 30. Нэг албан хаагчид ногдох материаллаг зардал

Зардлын төрөл	Зардлын нэр	1 жилд зарцуулах зардал (төгрөгөөр)
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид ногдох нийт зардал		5,395,434
Нийт албан хаагчид ногдох нийт зардал /0.15/		809,315.1



Уг хуулийн өөрчлөлт хэрэгжих тохиолдолд төрийн байгууллагуудад хүний нөөцийн зардал гарахгүй буюу одоо хэрэгжиж буй хуулийн чиг үүргийг хэрэгжүүлж буй алба хаагч хуулийн төсөлд шинээр орж ирсэн “олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг нэмж гүйцэтгэх боломжтой. Өөрөөр хэлбэл Байгал орчин, аялал жуулчлалын яамны алба хаагч жилд нэг удаа 120 минут болох 2 цаг, аймаг, нийслэлийн засаг даргын байгуулсан ажлын алба жилд 12 удаа, 1440 минут болох 24 цаг буюу нэг сард 2 цаг зарцуулан хийх боломжтой тул урсгал зардал, зардал, элэгдэл хорогдлын 809,315.1 төгрөгийн зардал тус тус үүснэ.

6.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнө нь тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах, дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана.

Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх

Байгаль орчин, аялал жуулчлалын яам “агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг жил бүр Улсын Их Хуралд тайлагнаж олон нийтэд мэдээлэх”, “Аймаг, нийслэлийн Засаг дарга агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг тайлагнаж олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий албыг байгуулж ажиллуулна” гэсэн нь жилдээ нэг удаа хийгдэх боломжтой үйл ажиллагаа тул үүнийг багасгах боломжгүй.

Мэдээллийн агуулгыг багасгах боломжтой эсэх;

Хуулийн төслийн дагуу олон нийтэд мэдээлэх мэдээлэл нь агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан болон агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг тайлан байна. Агаарын тухай хуулийн 6.1.4 дэх заалтад уг хэрэгжилтийг жилдээ нэг удаа олон нийтэд тайлагнахаар тусгасан бол тус хуулийн 15.6 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн бүсэд мөрдөх журам, энэ хуульд заасны дагуу зохицуулна” гэж заасан ба Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/424, А/1353 дугаар хамтарсан тушаал, захирамжийн 2 дугаар хавсралтаар¹⁵ баталсан “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам”-ын 5.1.1 дэх заалтад “журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага хяналт, шалгалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайланг сар тутам” гэж заасан тул жилд 12 удаа хийх ёстой. Гэвч хуульд заасан журам 2022 оноос хойш шинэчлэгдэж гараагүй ба журмыг баталсан тушаал, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт даалгасан ба тус газрыг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар тогтоолоор татан буулгасан тул тушаал, захирамжийг шинэчлэн батлах шаардлагатай байгаа юм.

¹⁵ Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/424, А/1353 дугаар хамтарсан тушаал, захирамжийн 2 дугаар хавсралт,
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532103597771&showType=1>

VII. ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар гэрч, хохирогчийг хамгаалах субъект, эрсдэлийн үнэлгээний түвшин болон нэр томъёоны асуудлыг шийдвэрлэхийг зорьсон байна.

Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Төрийн байгууллагын бүтэц бүрэлдэхүүн, зардал, ажлын ачаалалд нөлөө үзүүлэх боломжтой зохицуулалтыг сонгож авахдаа Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд зааснаар тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.6, 10.7 дахь хэсгүүд, 12 дугаар зүйл, 13 дугаар зүйлийн 13.2, 13.9, 13.10 дахь хэсгийг сонгон авлаа.

6.2. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

4. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
5. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
6. Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах;

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хүрээнд төрийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төслийн 10.3 дахь хэсгийн зардлын тооцоог хийхдээ “Биечилсэн хамгаалалтыг энэ хуулийн 23.1-д заасан эрх бүхий байгууллагаас томилогдсон алба хаагч байрлаж болон хөдөлгөөнтэйгөөр, ил болон далд хэлбэрээр зохион байгуулна” гэсний “байрлаж, болон хөдөлгөөнтэйгөөр ил болон далд хэлбэрээр зохион байгуулна” гэсэн хэсэгт зардал үүсэх боломжтой байна.

Биечилсэн хамгаалалтыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 10.2 дугаар хэсэгт “Энэ хуулийн 10.1-д заасан хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн харуул хамгаалалтын бүсэд хэрэгжүүлж болно.”

гэж зааснаар зохион байгуулдаг, мөн тус хуульд зааснаар 23.1 дэх хэсэгт “23.1.1. Цагдаагийн алба, 23.1.4. Авлигатай тэмцэх газар, 23.1.5. Тагнуулын ерөнхий газар” гэрч, хохирогчийн хамгаалахаар заажээ.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь тус хуультай холбогдон гарсан журмын зарим заалтыг хуульд тусгасан байна.

Үүнд:

- “Биечилсэн хамгаалалтын журам”-ын 2.2 дахь хэсгийг хуулийн төслийн 2/10.6.1 дүгээр заалтаас 10.6.3 дахь заалтад тусгасан ба журамд хамгаалалтын хэлбэрийг тодорхойлсон бөгөөд мөн орчны болон далд хамгаалалтын хэлбэрүүдийг тодорхойлжээ.
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн А/107 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журам”-д заасан зохицуулалтуудыг хуулийн төслийн 21¹ дүгээр зүйлд тусгасан байна.
- Хууль зүйн сайдын 2014 оны А/113 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам”-д хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1/12-т тусгасан байна.

Эдгээрээс зардал тооцох боломжтой хэсгүүдийг харьцуулан авч үзвэл. Үүнд:

Хүснэгт 31. Хуулийн төсөл ба одоо хэрэжиж буй хууль, журмын харьцуулалт

№	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Хүчинтэй журам
1.	10.3 “Биечилсэн хамгаалалтыг энэ хуулийн 23.1-д заасан эрх бүхий байгууллагаас томилогдсон алба хаагч байрлаж болон хөдөлгөөнтэйгөөр ил болон далд хэлбэрээр зохион байгуулна”	Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2014 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн А/204 дугаар тушаалаар баталсан “Биечилсэн хамгаалалтын журам”-ын <ul style="list-style-type: none"> - 1.4-т “Биечилсэн хамгаалалтыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т заасан байгууллагаас томилогдсон ажилтан /цаашид “Хамгаалагч” гэх/ хэрэгжүүлнэ.” - 2.1.Хамгаалалтын арга хэмжээний хэлбэр: <ul style="list-style-type: none"> - 2.1.1.биечилсэн хамгаалалтын үед хамгаалагч нь хамгаалуулагч этгээдийг биечлэн дагаж, хамгаална; - 2.1.2.орчны хамгаалалтын үед хамгаалагч нь хамгаалуулагч этгээдийг гадуур зорчих үед тэдний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор тодорхой чиглэл, орчинд ил хэлбэрээр хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулна; - 2.1.3.далд хамгаалалтын үед хамгаалагч нь хамгаалуулагч этгээдийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор тэдний ажиллаж, амьдарч, байрлаж байгаа орчин, явах зам, чиглэлийн дагуу заналхийлэгч этгээдийг илрүүлэх, үйдлийг нь таслан зогсоох, хамгаалуулагч этгээдээс бусад хүнд мэдэгдэхгүйгээр арга хэмжээг зохион байгуулна.
2.	10.6 “Биечилсэн хамгаалалт нь хамрах хүрээ, хүч хэрэгсэл, нөхцөл байдал, аюулын эрсдэлээс	- 2.2.Хамгаалалт нь хамрах хүрээ, хүч хэрэгсэл, нөхцөл байдлаас шалтгаалан дараах түвшинтэй байна:2.2.1.нэгдүгээр;2.2.2.хоёрдугаар;2.2.3.гуравдугаар. - 2.3.Нэгдүгээр түвшний хамгаалалтын үед хамгаалуулагч этгээдийн амь насанд бодитой аюул, заналхийлсэн, бие

	<p>шалтгаалан дараах түвшинтэй байна.”</p> <p>10.6.1 “Нэгдүгээр түвшний хамгаалалтыг энэ хуулийн 22.3.1-д заасан аюулын эрсдэлийн түвшин өндөр тогтоогдсон үед 24 цагаар, тодорхой хугацаанд тасралтгүйгээр зохион байгуулна”</p> <p>10.6.2. “Хоёрдугаар түвшний хамгаалалтыг энэ хуулийн 22.3.2-т заасан дунд түвшний аюулын эрсдэлд тогтоогдсон үед зохион байгуулна.”</p> <p>10.6.3. “Гуравдугаар түвшний хамгаалалтыг 22.3.3-т заасан аюулын эрсдэлийн түвшин бага тогтоогдсон үед зохион байгуулна.”</p>	<p>махбодид хохирол учруулсан, тарчлаасан, байнгын дарамтад байлгасан, гэмт хэрэг үйлдэхийг тулган шаардсан зэрэг өндөр эрсдэлтэй нь тогтоогдсон үед 24 цагаар, тодорхой хугацаанд тасралтгүйгээр энэ журмын 2.1.1-2.1.3-д заасан хэлбэрээс сонгож болон давхар арга хэмжээг зохион байгуулж болно.</p> <p>- 2.4.Хоёрдугаар түвшний хамгаалалтын үед хамгаалуулагч этгээдийг айлган сүрдүүлсэн, дарамталсан, дагаж мөшгөсөн, ятгасан, нөлөөлсөн, мөнгө эд зүйл, албан тушаал амласан зэрэг эрсдэл тогтоогдсон үед энэ журмын 2.1.1-2.1.3-д заасан хэлбэрээс сонгож болон давхар арга хэмжээг зохион байгуулж болно.</p> <p>- 2.5.Гуравдугаар түвшний хамгаалалтын үед хамгаалуулагч этгээдтэй уулзах, харилцаа тогтоохыг оролдох зэрэг эрсдэл учирч болзошгүй нь тогтоогдсон үед энэ журмын 2.1.2-д заасан хэлбэрээр арга хэмжээг зохион байгуулна.</p>
3.	<p>10.7. “Эрх бүхий байгууллага энэ хуулийн 21.10-т заасан гэрч, гэрч, хохирогчтой харилцан тохиролцож байгуулсны үндсэн дээр хамгаалалтыг хэрэгжүүлнэ.”</p>	<p>3.3.Хамгаалалтад авах тухай шийдвэрийг үндэслэн эрх бүхий байгууллагаас хамгаалуулагч этгээдтэй хамгаалалтын арга хэмжээний нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор тусгайлан гэрээ байгуулна.</p> <p>3.4.Хамгаалагч болон хамгаалуулагч этгээдийн эрх үүргийг энэ журмын 3.3-д заасан гэрээгээр зохицуулна.</p> <p>3.5.Хамгаалуулагч этгээд нь хамгаалалтын үйл ажиллагаанд харш аливаа сөрөг үйлдэл хийхийг хориглох тухай энэ журмын 3.3-д заасан гэрээнд тусгана.</p> <p>3.6.Хамгаалуулагч этгээд нь хамгаалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, хамгаалагчаас явуулж буй үйл ажиллагаанд харш аливаа үйлдэл гаргасан тохиолдолд хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага гэрээнд өөрчлөлт оруулах, цуцлах саналаа Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтад заасан албан тушаалтанд хүргүүлж, хамгаалалтын арга хэмжээг цуцлах шийдвэр гаргуулна</p> <p>3.7.Насанд хүрээгүй хамгаалуулагчийн хувьд түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй энэ журмын 3.3-д заасан гэрээг байгуулна.</p>
4.	<p>12.1. “Гэрч, хохирогчийг хувийн хамгаалалтыг нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангаж, шаардлагатай тохиолдолд түүний биед болон орон байранд тусгай техник хэрэгсэл суурилуулж болно.”</p>	<p>Гэрч, хохирогчийн хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлд:</p> <p>12.1.Гэрч, хохирогчийг Хувийн хамгаалалтын тухай хуулийн 12.1-д заасан нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангаж, шаардлагатай тохиолдолд түүний биед болон орон байранд тусгай техник хэрэгсэл суурилуулж болно.</p>

5.	<p>13 “Аюулгүй газарт түр байрлуулах”</p> <p>13.2. “Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.”</p> <p>13.9 “Түр байрлуулан хамгаалах байр болон үйлчилгээ нь хүний ялгаатай хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх бөгөөд нарийвчлан зохицуулсан стандартыг холбогдох байгууллагаар батлуулан мөрдөж ажиллана.”</p> <p>13.10. “Түр байрлуулан хамгаалах байрны үйлчилгээ нь үнэ төлбөргүй байх бөгөөд зардлыг улсын төсөв болон хуульд заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.”</p>	<p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/73 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”-ын</p> <ul style="list-style-type: none"> - 1.2.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийг үндэслэн хамгаалуулагчийн өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй хамгаалуулагчийг түүний эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.2-д заасан эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр аюулгүй байдал хангагдсан газарт буюу хамгаалах болон тусгай хамгаалах байранд бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна. - 2.2.Хамгаалах болон тусгай хамгаалах байр нь MNS 6040:2009 Монгол Улсын стандартын шаардлагыг хангасан байх бөгөөд үйл ажиллагааны дотоод журамтай байна. - 2.3.Энэ журмын 2.2-д заасан үйл ажиллагааны дотоод журамд хамгаалалт хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтан болон хамгаалуулагч, насанд хүрээгүй хамгаалуулагч түүний эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын эрх үүрэг, хориглох зүйлийн талаар нарийвчлан тусгана. - 2.5.Хамгаалах болон тусгай хамгаалах байрны үйлчилгээ нь үнэ төлбөргүй байх ба зардлыг улсын төсөв болон хуульд заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.
----	---	--

Иймд одоогоор хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, журамд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан нэмэлт, өөрчлөлтүүд тусгагдан хэрэгжиж байгаа тул хуулийн төслийн зардалд өөрчлөлт орохгүй гэж үзэж байна.

VIII. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд аюулын зэргийн үнэлгээ хийх тохиолдол ба Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хохирогчид тусламж үзүүлэх зориулалттай Нэг цэгийн үйлчилгээний төв болон түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээг ялгамжтай байлгах үүднээс Нэг цэгийн үйлчилгээний төвийг зөвхөн эмнэлгийн байгууллагын дэргэд ажиллуулах өөрчлөлт оруулахаар тусгасан байна.

Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Төрийн байгууллагын бүтэц бүрэлдэхүүн, зардал, ажлын ачаалалд нөлөө үзүүлэх боломжтой зохицуулалтыг сонгож авахдаа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.8, 19 дүгээр зүйлийн 19.1.8, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.8, 31.9, 36 дугаар зүйлийн 36.1 дүгээр зүйлийг сонгон авлаа.

6.3. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

7. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;

8. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;

9. Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах;

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хүрээнд төрийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов.

Хүснэгт 32. Хуулийн төсөл, одоо хэрэгжиж буй хуулийн зүйл

№	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл	Одоо хэрэгжиж буй хууль
1.	23.8.Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хуулийн 23.2.1 “Гэмт хэрэг, зөрчлийн талаар тоо бүртгэл хөтөлөх, цахим мэдээллийн сан


	солилцох ажиллагааг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хуулиар зохицуулна.”	бүрдүүлж ашиглах, мэдээлэл гаргаж өгөх, дамжуулах”
2.	19.1.8.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34.3 дахь хэсэгт заасан журмын дагуу урамшуулах.”	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хуулийн 34 дүгээр зүйл 34.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцон тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн хүн, хуулийн этгээдийг урамшуулна. 34.2.Хуульд өөрөөр заагаагүй бол иргэний өгсөн мэдээллийн дагуу зөрчилд 200 хүртэл нэгжээр торгох шийтгэл оногдуулсан бол иргэнд тухайн шийтгэлийн 20 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний, 200-аас дээш нэгжээр торгох шийтгэл оногдуулсан бол 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно. 34.3.Энэ хуулийн 34.1, 34.2-т заасны дагуу урамшуулах хэлбэр, журмыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
3.	31.1.Цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, гомдол, мэдээллийн тохиолдол бүрд хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн үнэлгээ хийнэ. 31.8.Монгол хэл, бичиг мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчид орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар аюулын зэргийн үнэлгээг хийнэ. 31.9.Хүүхдэд учирсан аюулын зэргийн үнэлгээг хийхдээ эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл багш, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, сэтгэл зүйчийг байлцуулна.	31.1.Цагдаагийн алба хаагч хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн үнэлгээ хийнэ.
4.	36.1.Энэ хуулийн 33.1-д заасан үйлчилгээг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй 24 цагийн турш нэг цэгээс үзүүлэх чиг үүрэг бүхий нэг цэгийн үйлчилгээний төвийг эмнэлгийн байгууллагын дэргэд ажиллуулна.	33.1.Хохирогчид үзүүлэх үйлчилгээ дараах төрөлтэй байна: 33.1.1.аюулгүй байдлын хамгаалалт; 33.1.2.эмнэлгийн тусламж, үйлчилгээ; 33.1.3.сэтгэл зүйн үйлчилгээ; 33.1.4.нийгмийн халамжийн үйлчилгээ; 33.1.5.хүүхэд хамгааллын үйлчилгээ; 33.1.6.эрх зүйн туслалцаа; 33.1.7.холбон зуучлах үйлчилгээ.

Хүснэгт 33. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

№	Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
1.	Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	<p>23.8.Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох ажиллагааг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хуулиар зохицуулна.</p> <p>19.1.8.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34.3 дахь хэсэгт заасан журмын дагуу урамшуулах.”</p> <p>31.1.Цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, гомдол, мэдээллийн тохиолдол бүрд хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн үнэлгээ хийнэ.</p> <p>31.8.Монгол хэл, бичиг мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчид орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар аюулын зэргийн үнэлгээг хийнэ.</p> <p>31.9.Хүүхдэд учирсан аюулын зэргийн үнэлгээг хийхдээ эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл багш, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, сэтгэл зүйчийг байлцуулна.</p> <p>36.1.Энэ хуулийн 33.1-д заасан үйлчилгээг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй 24 цагийн турш нэг цэгээс үзүүлэх чиг үүрэг бүхий нэг цэгийн үйлчилгээний төвийг эмнэлгийн байгууллагын дэргэд ажиллуулна.</p>	<p>- Мэдээллийн сан бүрдүүлэх</p> <p>- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах</p> <p>- Учирсан, учирч болох эрсдэлд аюулын зэргийн үнэлгээ хийх</p> <p>- Хэл ярианы бэрхшээлтэй хохирогчид орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар аюулын зэргийн үнэлгээг хийх</p> <p>-</p>

Үүнээс үзэхэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34.3 дахь хэсэгт заасан журмын дагуу урамшуулах зардлыг тооцвол:

- Иргэний мэдээлсэн зөрчлийн торгууль 200,000 хүртэл бол үүний 20 хувь, 200,000 дээш бол үүний 10 хувиар бодож иргэнд урамшуулал олгоно.



Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хуулиар зохицуулсан байх тул үүн дээр зардал тооцох шаардлагагүй.

Цагдаагийн алба хаагч, аймаг, нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, гомдол, мэдээллийн тохиолдол бүрд хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн үнэлгээ хийнэ. Ингэхдээ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан 2017 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн А/1201, А/178 дугаар тушаалаар батлагдсан “Журам батлах тухай” нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг баримтална.

Иймд монгол хэл, бичиг мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчид орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар аюулын зэргийн үнэлгээг хийх болон хүүхдэд учирсан аюулын зэргийн үнэлгээг хийхдээ эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл багш, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, сэтгэл зүйчийг байлцуулах хийхдээ Цагдаагийн ерөнхий газраас Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хамтран ажиллах тухай албан бичиг хүргүүлэн төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааны үндсэн дээр үнэ төлбөргүй хамтран ажилладаг байна.


Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байр нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 06 сарын 23-ны өдрийн А/116 дугаар тушаалаар баталсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”-ыг баримтална. Хуулийн төсөлд заасан “үйлчилгээг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй 24 цагийн турш нэг цэгээс үзүүлэх чиг үүрэг бүхий нэг цэгийн үйлчилгээний төвийг эмнэлгийн байгууллагын дэргэд ажиллуулна” гэсэн нь одоогийн үйл ажиллагааг удирдаж буй байгууллагыг солих тухай тул зардал тооцох шаардлагагүй байна. Мөн түр хамгаалах байр нь одоогийн байдлаар 24 цагийн үйл ажиллагаа явуулдаг ба энэ талаар дээрх журамд дэлгэрэнгүй заасан байна.

ДҮГНЭЛТ

Хуулийн төсөлд зардлын тооцоо хийх нь хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан гаргах зорилготой. Үүний хүрээнд, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар үүсэх зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ыг баримтлан тооцов.

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд цагдаагийн албан хаагчийг мэргэшүүлэх, ур чадварыг хөгжүүлэх, албан тушаалын буюу ажлын байрны сургалтад хамруулах, албаны нохой ашиглах болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсгийн аюулгүй ажиллагааны сургалтыг төлбөртэй зохион байгуулахаар тусгасан. Дээр дурдсанчлан, хуулийн төслийн 17 дугаар зүйлийн 17.3-т “Энэ хуулийн 17.1.1-д заасан сургалтын хөтөлбөр, агуулга, журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж заасан тул уг чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой стандарт ажиллагааг, хуулийн төслийн 17.1.3-т заасан албан тушаалын буюу ажлын байрны сургалтын чиг үүрэг нь тус байгууллагад шинээр нэмэгдүүлсэн чиг үүрэг биш байх тул зардлын тооцооноос тус тус хассан болно. Иймд, Хууль зүй, дотоод хэргийн сайд “Цагдаагийн алба хаагчийн албан тушаалын онцлог, хариуцсан ажил, үндсэн чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой сургалтын хөтөлбөр, агуулга, журам”-ыг батлахад энд тооцоолсон зардал сургалтын журам, хөтөлбөрөөс хамааран нэмэгдэхийг анхаарах нь зүйтэй. Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 17.1.2-т заасан “Цагдаагийн алба хаагчийн хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, тусгай хэрэгсэл хэрэглэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг дадал, ур чадварыг эзэмшүүлэх чиглэлээр зохион байгуулах ур чадвар хөгжүүлэх сургалтад хамруулах”-тай холбогдон гарах зардлыг тооцооллоо. Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд цагдаагийн байгууллага хүний нөөцийн цалингийн зардалд 26,047,817 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 5,756,928 төгрөг, нийт 31,804,745 төгрөгийн зардал үүсэхээр байна. Дээрх зардлыг бууруулах үүднээс хуулийн төслийн 17.4-т “Цагдаагийн алба хаагчийг мэргэшүүлэх, ур чадвар хөгжүүлэх, албан тушаалын буюу ажлын байрны сургалт явуулах төвийг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулж болно.” гэж заасны дагуу, сургалтын төвийг бүсчлэн байгуулснаар цагдаагийн байгууллага бүрд үүсэх хүний нөөцийн ачааллыг бууруулахаар байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд “хохирогч”-ийг ялгаатай байдлаар тодорхойлсныг засаж хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хүрээнд хамгаалагдах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийн хохирогч нь гадаадын иргэн, хэл яриа, хараа, сонсголын бэрхшээлтэй бол өөрт нь ойлгомжтой хэлбэрээр мэдээлэл авах эрхтэй байх талаар зохицуулсан. Хүн худалдаалах гэмт хэргийн тохиолдлын дундаж тоог тодорхойлох боломжгүй тул хохирогчийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн чиг үүргийг цагдаагийн байгууллагын тасралтгүй хэрэгжүүлэх үүрэг гэж үзэн тохиолдлын тоог стандарт үйл ажиллагаа бүрд 1 гэж тооцоолоход цагдаагийн байгууллага хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах хүний нөөцийн цалингийн зардалд нийт



227,174 төгрөг, хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 420,834 төгрөг, нийт 648,008 төгрөгийн зардал үүсэхээр байна. Өөрөөр хэлбэл, тухайн жилд хүн худалдаалах гэмт хэргийн тоо хэд бүртгэгдэхээс хамаарч зардалд шууд нөлөөлөхөөр байна.

Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр нууцад хамааруулах мэдээллийн шалгуур үзүүлэлтийг тогтоож, албаны мэдээллийг тухайн байгууллагын дарга баталж байгааг өөрчилж, тагнуулын байгууллагын дарга баталдаг байхаар тусгажээ. Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасны дагуу нууц хамгаалах ажилтан нь төсөлд заасан /албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ил болгох мэдээлэл байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх/ чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй байна. Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ил болгох мэдээллийн дүн шинжилгээг жилд нэг удаа гүйцэтгэхэд 3.25 өдрийг зарцуулах тул төрийн байгууллага, хуулийн этгээдүүд шинээр орон тоо нэмэгдүүлэх шаардлагагүй буюу одоогийн бүтэц, орон тоонд тулгуурлан чиг үүргийг хэрэгжүүлэх боломжтой байгааг тогтоолоо.

Хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд харуул хамгаалалтын нэгж, харуул хамгаалалтын ажилтны хувьд Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхэд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журмын 5.1-т "Хамгаалалтын нэг ээлжинд 3-аас доошгүй хамгаалалтын ажилтан үүрэг гүйцэтгэхээр зохион байгуулна." гэж заасан байна. Энэхүү журмыг баримтлан харуул хамгаалалтын ажилтныг 2 ээлжээр, 6 ажилтантай байхаар тооцоолон хүний нөөцийн зардалд 109,614,312 төгрөг, материаллаг зардалд 32,372,604 төгрөг, нийт **141,986,916** төгрөгийн зардал төрд үүсэхээр байна.

Хуулийн төсөлд хамаарах харуул хамгаалалтын ажилтны хийх үйл ажиллагаа нь хэдэн жилээр ч үргэлжлүүлэн хэрэгжүүлж болох бөгөөд энэ нөхцөлд шаардагдах хүний нөөцийн чиг үүрэг нь нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаа тул уг зардлын тооцооны хүрээнд үүнээс бууруулах боломжгүй юм. Мөн Хуулийн төслийн 190.5.5 дах хэсгийн харуул хамгаалалтын ажилтанд хамаарах чиг үүргийг Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхэд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журмын дагуу эмчлүүлэгчдээс гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хэргийн газрыг хамгаалалтад авч, нэн даруй Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, цагдаагийн байгууллага, эмнэлгийн захиргаанд мэдэгдэнэ гэж тодорхойлсон. Уг чиг үүргийн давтамж нь үргэлжилсэн шинжтэй, тодорхойлох боломжгүй тул мэдээллийг тухай бүр хүргүүлэх нь үр дүнтэй байх учир давтамжийг багасгах чиглэл баримтлах нь зохимжгүй. Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс мэдээллийн агуулгыг хязгаарлалгүйгээр мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангахад чиглэх нь зүйтэй. Эмчлүүлэгчдээс гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хэргийн газрыг хамгаалалтад авч, нэн даруй Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, цагдаагийн байгууллага, эмнэлгийн захиргаанд мэдэгдэхэд яаралтай шинжтэй тул цахимаар хүргүүлэх боломжгүй байна. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, цагдаагийн байгууллага, эмнэлгийн захиргаанд мэдэгдэхэд зайлшгүй шаардлагатай тул мэдээлэл хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжгүй юм.